



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/039/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас: 51-261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч.....	9
3.1.1 Зөвлөмж	9
3.2 Түүврийн байгууллага.....	10
3.2.1 Төлбөрийн акт	10
3.2.2 Зөвлөмж	10
4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МУ	Монгол Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН
СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА Б.ТУЛГА ТАНАА

2025.04.25 № 1620
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Хилийн боомтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 141.8 сая төгрөгийн балансын үнэтэй тусгай зориулалтын авто тээврийн хэрэгслийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны А-1/133 албан бичгийн дагуу Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын хөрөнгө оруулалтад Дорноговь аймгийн

Замын-үүд суманд “Гаалийн ажилчдын 30 айлын орон сууц” худалдан авах, засварлах 3,663.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөгдөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Ажлыг хуулийн хугацаанд гүйцэтгэж дуусгаагүй тул аж ахуйн нэгжид тайлант оны гүйцэтгэл 3,300.0 сая төгрөгийг урьдчилан олгож, үлдэгдэл төлбөр 363.1 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулан өглөгөөр бүртгэж, тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

Бусад асуудал

Төсвийн ерөнхий захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлсэн боловч Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан зарим мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлээгүй, аудитыг гүйцэтгэхэд хүндрэл учруулсан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	568,504.9	4,575,710.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	363,100.0
33	АВЛАГА	17,926.3	17,655.8
35	БАРАА МАТЕРИАЛ	550,578.6	531,854.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	3,663,100.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,814,044.2	30,935,290.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,814,044.2	30,935,290.4
39200	Биет хөрөнгө	33,813,177.5	30,905,893.8
39300	Биет бус хөрөнгө	866.7	29,396.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	34,382,549.1	35,511,001.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	363,100.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	34,382,549.1	35,147,901.1
51	Засгийн газрын хувь оролцоо	34,382,549.1	35,147,901.1
51200	Хуримтлагдсан үр дүн	34,382,549.1	35,147,901.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	34,382,549.1	35,511,001.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,721,577.9	11,113,360.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,192.0	105.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,674,385.9	11,113,255.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,282,230.3	10,221,377.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,282,230.3	10,221,377.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,299,129.6	9,178,689.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,308,400.9	1,726,106.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,173.7	222,108.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,473.4	146,658.1
2104	Хангамж, бараа материалын зардал	388,006.2	749,600.2
2105	Нормативт зардал	17,332.8	84,724.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	188,783.5	309,917.7
2107	Томилолт, зочны зардал	396,934.6	487,795.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,851.2	370,763.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,904,173.4	5,081,015.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,983,100.6	1,042,688.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	100,062.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,983,100.6	942,626.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(4,560,652.4)	891,982.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,635.9	126,630.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(4,587,288.4)	765,352.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,674,385.9	11,476,460.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	363,205.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,674,385.9	11,113,255.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,393,144.1	5,267,326.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,393,144.1	5,267,326.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,410,043.5	4,224,638.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,308,671.3	1,726,106.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,173.7	221,837.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,473.4	146,658.1
2104	Хангамж, бараа материалын зардал	422,393.3	535,228.0
2105	Нормативт зардал	39,715.0	85,833.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,932.5	382,553.7
2107	Томилолт, зочны зардал	396,646.4	553,297.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,698.5	417,915.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,339.2	155,208.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,983,100.6	1,042,688.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	100,062.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,983,100.6	942,626.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	281,241.8	6,209,133.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	281,241.8	5,846,033.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(281,241.8)	(5,846,033.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	363,100.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	363,100.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	38,969,837.4	38,969,837.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	38,969,837.4	38,969,837.4
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,587,288.4)	(4,587,288.4)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	34,382,549.1	34,382,549.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	34,382,549.1	34,382,549.1
Тайлант үеийн үр дүн	-	-	765,352.0	765,352.0
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	35,147,901.1	35,147,901.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,176,340,400.00	10,124,871,402.03	5,460,100,000.00	90.6
УРСГАЛ ЗАРДАЛ	5,713,240,400.00	4,664,771,402.03	1,048,468,997.97	81.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,507,230,400.00	4,564,709,402.03	942,520,997.97	82.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,774,703,300.00	1,680,243,749.41	94,459,550.59	94.7
Үндсэн цалин	1,262,750,900.00	1,149,357,396.22	113,393,503.78	91.0
Нэмэгдэл	390,859,500.00	327,637,690.74	63,221,809.26	83.8
Унаа хоолны хөнгөлөлт	121,016,200.00	103,507,270.65	17,508,929.35	85.5
Урамшуулал	76,700.00	99,741,391.80	(99,664,691.80)	130040.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,837,800.00	221,837,800.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	150,849,700.00	150,849,700.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	17,747,100.00	17,747,100.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	14,197,500.00	14,197,500.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,549,400.00	3,549,400.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	35,494,100.00	35,494,100.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	489,911,400.00	146,658,110.00	343,253,290.00	29.9
Гэрэл, цахилгаан	99,865,800.00	70,968.00	99,794,832.00	0.1
Түлш, халаалт	36,493,200.00	4,780,243.00	31,712,957.00	13.1
Цэвэр, бохир ус	94,568,400.00	692,876.00	93,875,524.00	0.7
Байрны түрээс	258,984,000.00	141,114,023.00	117,869,977.00	54.5
Хангамж, бараа материалын зардал	801,608,800.00	547,384,236.82	254,224,563.18	68.3
Бичиг хэрэг	50,325,700.00	42,672,975.00	7,652,725.00	84.8

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тээвэр, шатахуун	622,625,000.00	417,781,000.00	204,844,000.00	67.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,682,800.00	26,740,631.82	30,942,168.18	46.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,210,300.00	-	7,210,300.00	0.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,765,000.00	60,189,630.00	3,575,370.00	94.4
Нормативт зардал	89,074,800.00	85,833,361.00	3,241,439.00	96.4
Хоол, хүнс	52,974,000.00	52,659,561.00	314,439.00	99.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,100,800.00	33,173,800.00	2,927,000.00	91.9
Эд хогшил, урсгал засварын зардал	747,318,500.00	724,422,328.00	22,896,172.00	96.9
Багаж, техник, хэрэгсэл	315,060,000.00	314,314,938.00	745,062.00	99.8
Тавилга	55,126,000.00	51,193,520.00	3,932,480.00	92.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,167,500.00	14,893,700.00	2,273,800.00	86.8
Урсгал засвар	359,965,000.00	344,020,170.00	15,944,830.00	95.6
Томилолт, зочны зардал	736,731,000.00	553,297,156.80	183,433,843.20	75.1
Гадаад албан томилолт	274,680,000.00	273,854,611.80	825,388.20	99.7
Дотоод албан томилолт	290,376,000.00	193,429,550.00	96,946,450.00	66.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	171,675,000.00	86,012,995.00	85,662,005.00	50.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	465,003,800.00	449,824,560.00	15,179,240.00	96.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	346,450,000.00	340,168,191.00	6,281,809.00	98.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,943,000.00	-	2,943,000.00	-
Даатгалын үйлчилгээ	17,216,500.00	17,187,510.00	28,990.00	99.8
Тээврийн хэрэгслийн татвар	3,433,500.00	2,197,691.00	1,235,809.00	64.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	784,800.00	22,000.00	762,800.00	2.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	93,195,000.00	90,199,168.00	2,995,832.00	96.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	981,000.00	50,000.00	931,000.00	5.1
Бараа үйлчилгээний бусад зардал	181,041,000.00	155,208,100.00	25,832,900.00	85.7
Бараа үйлчилгээний бусад зардал	145,725,000.00	141,947,300.00	3,777,700.00	97.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,316,000.00	13,260,800.00	22,055,200.00	37.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,010,000.00	100,062,000.00	105,948,000.00	48.6
Бусад урсгал шилжүүлэг	206,010,000.00	100,062,000.00	105,948,000.00	48.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,948,000.00	-	105,948,000.00	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,062,000.00	100,062,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,463,100,000.00	5,460,100,000.00	3,000,000.00	99.9
Барилга байгууламж	3,663,100,000.00	3,663,100,000.00	-	100.0
Тоног төхөөрөмж	1,800,000,000.00	1,797,000,000.00	3,000,000.00	99.8

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,176,340,400.00	10,124,871,402.03	1,051,468,997.97	90.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,176,340,400.00	10,124,766,402.03	1,051,573,997.97	90.6
Улсын төсвөөс санхүүжих	11,176,340,400.00	10,124,766,402.03	1,051,573,997.97	90.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	105,000.00	(105,000.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	105,000.00	(105,000.00)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	52	-	100.0
Удирдах ажилтан	5	5	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	47	47	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52	52	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	51	51	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		45,862,559.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		45,862,559.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		45,862,559.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		45,862,559.00
210104	Урамшуулал		45,862,559.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		45,862,559.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		45,862,559.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		45,862,559.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,663.1 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Хилийн боомтын захиргаа нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар тайлант онд хэрэгжиж дуусахаар 3,663.1 сая төгрөгөөр батлагдсан "Гаалийн ажилчдын албаны орон сууц худалдаж авах, засварлах /Дорноговь, Замын-Үүд сум/" арга хэмжээний санхүүжилтэд урьдчилж олгосон 3,300.0 сая төгрөгийн гүйлгээг бүртгэхдээ Санхүүгийн байдлын тайланд дараах алдаатай бүртгэлийг хийсэн байна. Үүнд:

- Худалдан авсан барилгын санхүүжилтийг олгохдоо аж ахуйн нэгжрүү шилжүүлсэн 3,300.0 сая төгрөг, гүйцэтгэл гараагүй засварын ажлын 363.1 сая төгрөг, нийт 3,663.1 сая төгрөгөөр бусад эргэлтийн хөрөнгийн дүнг хүлээн зөвшөөрч, эздийн өмч 3,300.0 сая төгрөгөөр, өр төлбөрийг 363.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн;
- Төсвийн шууд захирагчийн авлага дансанд бүртгэлтэй 3,300.0 сая төгрөгийг барилга байгууламж дансанд бүртгүүлж, авлагыг бууруулсан байна.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дараах алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 70.2 сая төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 17.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 52.7 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 70.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32.0 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч

3.1.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын харьяа байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,663.1 сая төгрөгийн 1 алдаа, 70.2 сая төгрөгийн 2 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 5,347.2 сая төгрөгийн 9 зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг 50.0 хүртэлх хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах.

1

3.2 Түүврийн байгууллага

3.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Блэссэд софтвейр ХХК-тай Вебсайт хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний 17.5 сая төгрөгийн гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлын тайлан бичигдээгүй, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нотлох баримтаар дэмжигдээгүй ажлын гүйцэтгэлд олгосон 17.5 сая төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэх **төлбөрийн акт тогтоов.**

3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллага нь Сангийн сайдын тушаал зөрчиж өөрийн үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарахгүй хоол хүнсний зардлыг /210502/ төсөвт төлөвлөж 52.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зөөвөр"-ын "Хоол, хүнсний зардал (210502) Тогтоосон норм, нормативын дагуу тоо хэмжээг нь тогтоосон хүнсний бүтээгдэхүүн, хоол хүнсийг хангах үйлчилгээ (эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоол, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн дотуур байрны хоолны зардал, хугацаат цэргийн албан хаагч, сэжигтэн, хоригдлын хоолны зардал, хил дээр ажиллаж байгаа офицер, ахлагчийн хүнсний хангамж) зардал энд хамаарна. Хамаарахгүй зүйлс: Ажилласан хугацаанд хамааруулан хууль журмын дагуу хувь хүнд мөнгөн хэлбэрээр олгож байгаа хоол, хоолны хөнгөлөлтийн зардал. Энэ нь Унаа хоолны хөнгөлөлт (210103) ангилалд бүртгэгдэнэ... Хурал зөвлөгөөн сургалт, семинарын хоолны зардал. Энэ нь Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх (210902) ангилалд бүртгэгдэнэ. Ахмад настныг хүлээн авах, хүүхдийн баярын бэлэг бэлтгэх, баяр ёслол, хүндэтгэлийн зоог зохион байгуулахад гарах хоол, хүнсний зүйл бэлтгэх зардал. Энэ нь Бараа үйлчилгээний бусад зардал (210901) ангилалд бүртгэгдэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хэрэгцээ шаардлагыг бодитоор үнэлж, үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарахгүй төсвийг төлөвлөхгүй байх

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.1.1 Албан шаардлага

Түүврийн байгууллагагын хувьд

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Цалингаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий зарлагын 6,547.6 сая төгрөгийн 50 гүйлгээ, орлогын 11,103.7 сая төгрөгийн 23 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх" , 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх **албан шаардлага** хүргүүлэв.

4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.2.1 Албан шаардлага

Түүврийн байгууллага

Илрүүлэлт 1: Хилийн боомтын захиргааны холбогдох эрх бүхий албан тушаалтнууд нь хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Хилийн боомтын захиргаа нь 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй;
- Өмнөх оны аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, хугацаа хоцроосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны

төсвийн захирагчид хүргүүлэх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасантай нийцэхгүй, мөн хуулийн, 42 дугаар зүйлийн 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй Хилийн боомтын захиргааны холбогдох буруутай албан тушаалтанд **хариуцлага тооцох албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд туулах чадвар сайтай 9 ширхэг /нэгж үнэ 170.0 сая/, суудлын 2 ширхэг /нэгж үнэ 135.0 сая/ автомашиныг нийт 1,800.0 сая төгрөгөөр худалдан авалт хийхээр төсөвлөсөн бөгөөд худалдан авах үйл ажиллагааны явцад хөрөнгө оруулалтын нэр төрөл, тоо хэмжээ, үнэ зэрэгт өөрчлөлт орж 834.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдэл 966.0 сая төгрөгийг төсвийн дансанд төвлөрүүлэлгүй төсөвт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагаас давсан нийт 963.0 сая төгрөгөөр 5 автомашиныг /Nissan Patrol Y62-2ш, Nissan Leaf-2ш, Hyundai Elentra-1ш/ худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт тусгагдаагүй, хэрэгцээ шаардлагаас давсан үр, ашиггүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зориулж 41.6 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Хилийн боомтын захиргааны ажилчдын үндсэн цалин, шатлалыг тооцох хууль, эрх зүйн орчин тодорхойгүйгээс шалтгаалан төсвийн төслийн саналд АА цалингийн

шатлалаар санал хүргүүлэн, батлагдсан боловч ТҮ цалингийн шатлалаар цалинг тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.5-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хилийн боомтын захиргааны үндсэн цалинг тогтоох цалингийн шатлал хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан аль цалингийн шатлалд хамаарах эсэх нь тодорхойгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2024 онд баталсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд урсгал төсвөөс 260.0 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр худалдан авалтын төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалтаар багаж, техник, хэрэгслийн зардлаас нийт 262.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

4.2.2 Зөвлөмж

Төсвийн ерөнхийлөн захирагч

Илрүүлэлт 1: БНХАУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон Гашуунсухайт боомтын барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсан боловч Монгол Улсын хилийн тухай болон Гаалийн тухай хуулиудын давхардсан заалтуудаас шалтгаалан эзэмшигч тодорхойгүй, тус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын 4.4-т " Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.", Монгол улсын Хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн "29.9-т Ашигт малтмал, газрын тос, бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, улс хоорондын тээврийн зохицуулалт, халдвар хамгаалал, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог нэгдсэн зохицуулалтаар хангах, боомтын хөгжлийн асуудлыг төлөвлөх, орон сууц, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус болон бусад дэд бүтцийг хариуцаж, боомтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хилийн боомт дахь төрийн өмчийн бүртгэл, СНАГ-2025/039/НА-СТА-ТЕЗ

хяналтыг хариуцах чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг Засгийн газар байгуулна.", Гаалийн тухай хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1.1.10-т "хилийн боомтын барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцан зохион байгуулах, хилийн хяналтын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийг данс бүртгэлд тусгах асуудлыг Гаалийн ерөнхий газар болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн шийдвэрлэх.

Түүврийн байгууллага

Илрүүлэлт 2: Мөнгөн хөрөнгөөс нийт 607.3 сая төгрөгийн 48 гүйлгээг ажил гүйлгээний утга тодорхойгүй, "Гэрээний төлбөр" гэсэн агуулгаар зарцуулж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу "монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн зарцуулалтын гүйлгээний утганд гэрээний дугаар, арга хэмжээ, зориулалтыг үнэн зөв, тодорхой тусгаж хэвшүүлж ажиллах.

Илрүүлэлт 3: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хэрэгжүүлж байгуулсан 1,800.0 сая төгрөгийн 4 гэрээг Худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн санд байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг", 48 дугаар зүйлийн 48.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хэрэгжүүлж байгуулсан гэрээг Худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн санд байршуулж байх.

Илрүүлэлт 4: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 8,963.4 сая төгрөгийн 38 төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн боловч 6,683.1 сая төгрөгийн 9 арга хэмжээний гүйцэтгэлийг тайлагнаж, 2,280.3 сая төгрөгийн 27 ажлын гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ

бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнаж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйл нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ												
Хилийн боомтын захиргаа	1	3,663.1			1	3,663.1	1	3,663.1				
Нийт дүн	1	3,663.1			1	3,663.1	1	3,663.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ												
Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга	1	-					1	-				
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ												
Хилийн боомтын захиргаа	2	70.2	1	17.5			1	52.7				
Нийт дүн	3	70.2	1	17.5			2	52.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ										
Хилийн боомтын захиргаа	1	-			1	-				
Дүн	1	-			1	-				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ										
Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга	1	-					1	-		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ										
Хилийн боомтын захиргаа	8	5,347.2			4	1,266.9	3	4,080.3	1	2
Дүн	9	5,347.2			4	1,266.9	3	4,080.3	1	2
Нийт дүн	10	5,347.2			5	1,266.9	4	4,080.3	1	2